

[illegible]

Бизнес, инновацын зөвлөх үйлчилгээний
13 ЖИЛИЙН ТУРШЛАГАТАЙ, мэргэшсэн, мэргэжлийн, хараат бус зөвлөх
үйлчилгээний ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА юм.

БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Бизнес, инновацын зөвлөх үйлчилгээний МИРИМ Консалтант ХХК нь 2008 оноос үйл ажиллагаагаа явуулж 2013 онд албан ёсоор байгуулагдсан, мэргэшсэн, мэргэжлийн, хараат бус зөвлөх үйлчилгээний байгууллага юм. Манай байгууллага улс төр, бизнес, нийгмийн бүхий л салбарт судалгаа, сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.



БАЙГУУЛЛАГЫН ҮНЭТ ЗҮЙЛС

Бид шинэ мэдлэг, холч шийдэлтэй зөвлөх үйлчилгээг харилцагчдадаа хүргэж, хамтдаа хөгжих эрхэм зорилготой. Харилцагчдадаа мэргэжлийн судалгаанд түшиглэн үр ашигтай шийдэл, үйл ажиллагааны онцлогт тохирсон бодитой, хэрэгжихүйц зөвлөх үйлчилгээг санал болгохоос гадна харилцан итгэлцэл, ёс зүйн зарчмыг баримтлан ажилладаг.

БҮТЭЭЛЧ:

Мэргэжлийн судалгаанд түшиглэж,
харилцагчдадаа үнэ цэнийг бий болгоно.
Үр ашигтай шийдэл, бодитой,
хэрэгжихүйц зөвлөгөөг санал болгоно.



ИТГЭЛЦЭЛ:


Зөвлөх үйлчилгээний үндэсний болон
олон улсын стандартыг мөрдөнө.
Судалгааны ёс зүйг баримталж,
мэдээллийн нууцлалыг чандлан
хадгална.



МОНГОЛ ТУРШЛАГА:

Монгол орны онцлог, орчин нөхцөлд
тохирсон шийдлийг санал болгоно.





ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

Манай компани судалгаа, менежментийн зөвлөгөө, сургалтын чиглэлийн хүрээнд харилцагч байгууллагадаа үнэ цэнийг бий болгохын тулд хамтран ажилладаг.



СУДАЛГАА

СУДАЛГАА:

Бид маркетинг, эдийн засаг, улс төрийн судалгаа болон байгууллагын маркетингийн үйл ажиллагааг сайжруулах, үр дүнг хэмжих, зардлыг бууруулах зорилгоор мониторинг, үнэлгээг хийдэг. Өнгөрсөн хугацаанд уг үйлчилгээний хүрээнд **90** гаруй байгууллагын захиалгаар **141** судалгааны ажлыг амжилттай гүйцэтгээд байна.



МЕНЕЖМЕНТИЙН ЗӨВЛӨГӨӨ

МЕНЕЖМЕНТИЙН ЗӨВЛӨГӨӨ:


Манай байгууллага бодит судалгаанд үндэслэн богино, дунд, урт хугацааны бизнес төлөвлөгөөг боловсруулдаг. Судалгаанаас гарсан үр дүндээ үндэслэн тухайн байгууллагын менежментийг сайжруулах, бизнесээ өргөжүүлэх боломжийн талаар зөвлөгөө, чиглүүлэг өгдгөөрөө давуу талтай. Одоогийн байдлаар **30** гаруй байгууллагын захиалгаар **39** менежментийн зөвлөгөөг амжилттай үзүүлээд байна.



СУРГАЛТ

СУРГАЛТ: Бид хэрэглэгчдийнхээ эрэлт хэрэгцээ, хүний нөөцийг чадваржуулах, тулгамдаж байгаа асуудлыг шийдэх зорилгоор байгууллага, аж ахуйн нэгжид зориулсан захиалгат сургалтыг тодорхой сэдвүүдийн хүрээнд захиалгаар зохион байгуулдаг. Сургалтыг онол болон практик дээр ажилласан туршлагатай мэргэжлийн зөвлөх багш нар заадгаараа онцлогтой. Өнгөрсөн хугацаанд **10** гаруй байгууллагын захиалгаар **20** сургалтыг амжилттай зохион байгуулсан.

1




2

3

БАЙГУУЛЛАГЫН ТУРШЛАГА

“МИРИМ Консалтант” ХХК нь 2008 оноос өнөөг хүртэл Монгол улс болон олон улсын түвшинд 200+ төслийг амжилттай хэрэгжүүллээ. Үүнээс 141 судалгаа, 39 менежментийн зөвлөх үйлчилгээ, 20 сургалтын үйлчилгээг тус тус үзүүлээд байна. Мөн 20 гаруй дата менежментийн төсөл болон 15 брэнд судалгааг хийж гүйцэтгэлээ.





ГАЗАРЗҮЙН ТУРШЛАГА: /Монгол Улсад:/

“МИРИМ Консалтант” ХХК нь 2021 оны байдлаар Улаанбаатар хот, 21 аймаг, нийт 330 гаруй сумдад нийт 345,800 км явж, 12,750 аж ахуйн нэгж, байгууллага, 135,000 гаруй иргэдээс судалгаа аваад байна. Бидний хэрэгжүүлсэн нийт төслийн 80 гаруй хувь бүс, үндэсний хэмжээг хамран хийгдсэн. Тиймээс бид хөдөө орон нутагт нэгэн зэрэг олон талбарын судалгаа явуулах нөөц, мэдлэг, туршлагатай. Бид ижил цаг хугацаанд 5-10 төсөл дээр зэрэг ажиллах чадамж бүхий төслийн багийн менежментийн схемийг бүрдүүлэн ажиллахын зэрэгцээ үндэсний хэмжээнд богино хугацаанд 2500-5000 өрхийг хамарсан судалгаанд 150 хүртэл судлаачийг нэгэн зэрэг ажиллуулж мэдээлэл цуглуулж байсан туршлагатай. Манай байгууллага нь түүвэр судалгааг өргөн хүрээнд явуулах чадавхтайн дээр нэлэнхий судалгааг 3 гурван аймагт хийж гүйцэтгэсэн туршлагатай.

ГАЗАРЗҮЙН ТУРШЛАГА: /Олон улсад:/

Бид ӨМӨЗО, АНУ, Япон, Герман, Чех, Хятад, Орос, Казакстан зэрэг оронд экспортын болон нууцлаг худалдан авалтын судалгаа ба зөвлөх үйлчилгээний чиглэлээр 10+ зөвлөх үйлчилгээг үзүүлээд байна. Манай байгууллага “Экспортыг дэмжих төсөл”-ийн хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Шилийн гол, Хөх хот, Алаша, Баяннуур, Ордос зэрэг аймаг, хотын иргэдээс судалгааны мэдээлэл цуглуулсан туршлагатай.

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУРШЛАГА

Бид одоогийн байдлаар нийт 130+ гаруй олон улсын байгууллага, төрийн байгууллага, бизнесийн байгууллага, ТББ, хувь хүнтэй хамтран ажиллаад байна.

МИРИМ Консалтант компани Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны зөвлөх компанийн жагсаалтад бүртгэлтэй бөгөөд зардал хуваалцах зарчмаар жижиг, дунд ААН-үүдэд зөвлөх үйлчилгээг үзүүлдэг. Энэ төслийн хүрээнд 13 байгууллагад хөнгөлөлттэй үнээр 14 төслийг хэрэгжүүлээд байна



7%

ТББ

30%

**Олон улсын
БАЙГУУЛЛАГА**

19%

**ТӨРИЙН
БАЙГУУЛЛАГА**

44%

**БИЗНЕСИЙН
БАЙГУУЛЛАГА**



European Bank
for Reconstruction and Development


ГИШҮҮНЧЛЭЛ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУД



ХАМТРАН АЖИЛЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД

МИРИМ Консалтант ХХК нь дараах байгууллагуудтай стратегийн түнш байгууллага болохоо батламжлан хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж хамтран ажиллаж байна.

СТРАТЕГИЙН ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД:




ХАРИЛЦАГЧТАЙГАА ХАМТРАН АЖИЛЛАХДАА:

Харилцагчийнхаа хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагад нийцсэн онцлог судалгаа болон зөвлөх үйлчилгээний аргачлалыг санал болгодог. Судалгааны эхлэлээс дуусах үе шат хүртэл бид захиалагчтайгаа нягт хамтарч ажилладагаараа онцлогтой. Бидний хамтын ажиллагаа тухайн үйлчилгээгээр хязгаарлагдахгүй бөгөөд урт хугацаанд бат бэх үргэлжлэх нөхцөл байдлыг бүрдүүлж, хэрэглэгчээ халамжлахыг бид зорьдог.

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХҮНИЙ НӨӨЦ

“МИРИМ Консалтант” ХХК нь бодлого, менежмент, үйл ажиллагаа гэсэн гурван түвшинд үйл ажиллагаагаа явуулж байна. Бодлогын түвшинд төлөөлөн удирдах зөвлөл, менежментийн түвшинд гүйцэтгэх захирал, үйл ажиллагааны түвшинд захиргааны баг, төсөл хөгжүүлэлт, хэрэгжүүлэлт, зөвлөх, туслах ажилтнуудын баг тус тус ажиллаж байна. Байгууллагын бүтцийг дараах зурагт харууллаа.

МИРИМ Консалтант ХХК нь дотоод зохион байгуулалтынхаа хүрээнд төслийн багийн схемээр ажилладаг. Тухайн төслийг хариуцсан мэргэжлийн баг гаргаж ажиллуулснаар ажлыг цаг хугацаанд нь мэргэжлийн түвшинд гүйцэтгэх боломжийг олгодог.



ТӨСЛИЙН БАГ:

Төслийн баг нь төсөл хөгжүүлэлт, төсөл хэрэгжүүлэгч гэсэн хоёр багт хуваагддаг. Төсөл хөгжүүлэлтийн баг нь төсөл бичих, босгох хэсгийг хариуцан ажилладаг бол төсөл хэрэгжүүлэлтийн баг нь төслийн бэлтгэл болон гүйцэтгэлийг хариуцан ажилладаг. Манай байгууллагад дунджаар 5-10 төслийн баг нэгэн зэрэг ажиллаж, хариуцсан төсөл, хөтөлбөрөө үр дүнтэй, цаг хугацаанд нь чанартай хэрэгжүүлж байна.

ЗӨВЛӨХИЙН БАГ:

МИРИМ Консалтант ХХК нь тухайн салбартаа мэргэшсэн зөвлөхийн багийг бүрдүүлж чадсан. Зөвлөхийн баг нь дотоод болон гадаад 70 гаруй зөвлөхийн сантай. Зөвлөхийн баг нь хэрэгжүүлж буй төслүүдэд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, гүнзгийрүүлсэн шинжилгээ хийх, тайлан бичих, дүгнэлт зөвлөмж гаргах чиглэлээр ажилладаг.

ГЭРЭЭТ СУДЛААЧИД:

Манай байгууллага гэрээт судлаачдын сантай бөгөөд одоогоор байнгын 300+ гэрээт судлаач, туслах ажилтан бүртгэлтэй ажиллаж байна. Эдгээр гэрээт судлаач нь жилийн дөрвөн улиралд судалгаагаар хот, хөдөөд ажилладаг бөгөөд орон нутгийн нөхцөл байдлын талаар сайн мэдлэг, туршлагатай, урт хугацаанд аялах, ачаалал даах чадвартай. Гэрээт судлаачид нь нийгэм, эдийн засгийн чиглэлээр бакалавр зэрэгтэй, доод тал нь нэг жилийн судалгааны мэдээлэл цуглуулах туршлагатай байх гэсэн шалгуурыг хангасан байдаг. Бид судлаачдаа талбарт ажиллахад хөдөлмөрийн аюулгүй байдлыг байнга ханган, анхаарч ажилладаг: Үүнд:

- Судалгааны талбарт ажиллаж байгаа судлаачдыг гэнэтийн ослын даатгалд хамруулдаг;
- Талбарт ажиллахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа, тухайн ажлын онцлог, учирч болох эрсдэл, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга замын талаар тогтмол сургалт зохион байгуулдаг;
- Судлаачийн аюулгүй байдлыг хангах үүднээс нулимс асгаруулагч, гар чийдэн, гар утас, зай баригч, яаралтай үед холбоо барих утасны дугаарын жагсаалт зэргээр тус тус хангадаг болно.

ХҮНИЙ НӨӨЦ:

“МИРИМ Консалтант” ХХК-д орон тооны 10 үндсэн ажилтан, мэргэшсэн 10+ үндсэн зөвлөх, 60+ гэрээт зөвлөх, 5 мэдээлэл оруулах ажилтан, 10+ чанарын хяналтын ажилтан, 300+ талбарын гэрээт судлаач ажилладаг. Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймагт мэдээлэл цуглуулах мэргэжлийн байнгын гэрээт судлаачидтай. Манай судлаач, мэргэжилтнүүд эдийн засаг, социологи, статистик, сэтгэл судлал, маркетинг, бизнесийн удирдлага, хууль, төслийн менежментийн чиглэлээр мэргэшсэн, тухайн салбартаа 10-аас дээш жилийн туршлагатай. Компани дээр хэрэгжсэн төслүүд дээр ажилласан судлаач, зөвлөхүүдийн нийлбэр туршлагыг үнэлбэл 705 жил болно.



БИДНИЙ ДАВУУ ТАЛ

Бид 2008 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд 130 гаруй байгууллагын захиалгаар 200 гаруй төслийг хэрэгжүүлсэн. Энэ хугацаанд бидний хэрэгжүүлсэн төслүүд дээр ажилласан судлаач, зөвлөхүүдийн ажилласан хугацаа, туршлагын нийлбэрийг үнэлбэл 705 хүн жилийн туршлагыг хуримтлуулжээ.



МЭРГЭЖЛИЙН БАТАЛГАА

МИРИМ Консалтант компани нь судалгаа шинжилгээний үе шат бүртээ Олон улсын социологийн холбооны ёс зүйн дүрэм болон “Стандартчилал хэмжил зүйн газар”-аас гаргасан “Гүнзгийрүүлсэн болон өгөгдлийн шинжилгээг багтаасан зах зээлийн, олон нийтийн санаа бодол болон нийгмийн судалгаа, нэр томъёоны тайлбар болон үйлчилгээнд тавих шаардлага” буюу MNS ISO 20252:2019 стандартыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО

Манай байгууллага дотоод үйл ажиллагаандаа чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 олон улсын стандартыг 2020 оноос нэвтрүүлэн ажиллаж байна. Бид энэхүү тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр хэрэглэгчид хүрч байгаа бүтээгдэхүүн үйлчилгээний чанар илүү сайжирна.





МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨХҮҮД

Манай байгууллага аливаа судалгаа, зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхдээ багийн зохион байгуулалтаар ажилладаг. Багийг бүрдүүлэхдээ тухайн чиглэлээр мэргэшсэн, салбартаа танигдсан зөвлөх, мэргэжилтнүүдийг ажиллуулдаг нь манай давуу тал юм. Манай компани 10+ үндсэн зөвлөх, 60+ гэрээт зөвлөх, 300+ гэрээт судлаачтай.



ЧАНАРЫН ХЯНАЛТ

Манай компани аливаа төсөл, судалгааны ажлыг хэрэгжүүлж эхлэхээс дуусах хүртэл бүхий л үе шатандаа чанарын хяналтыг хийдэг тогтолцоог нэвтрүүлсэн. Тухайлбал, хэрэглэгдэхүүнийг онлайн хэлбэрт оруулж, мэдээлэл цуглуулалтыг таблет болон ухаалаг утсаар цуглуулж, үйл явцыг бодит цаг хугацаанд нь (real time) хянадаг. Мэдээлэл цуглуулалтын программ нь ярилцлагын асуулга, аудио бичлэг, судалгаа авсан цэг, байршлыг төв серверт шууд дамжуулдаг. Ингэснээр судалгааг тухайн бүрд нь хянаж, талбараас үнэн зөв, чанартай мэдээлэл цуглуулах үндэс болдог.



ДАТА МЕНЕЖМЕНТ

Бид их өгөгдөлд тулгуурласан судалгаа, зөвлөх үйлчилгээг хөгжүүлэхээр зорин ажиллаж байна. Энэ хүрээнд өгөгдлийн санг бүрдүүлэх, их өгөгдөлд дүн шинжилгээ хийх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Өгөгдлийн сан бүрдүүлэхдээ өгөгдлийн сангийн бүтэц, технологи, дэд бүтцийг хослуулан хөгжүүлэлт хийж байгаа бол өгөгдөлд дүн шинжилгээ хийхдээ орчин үеийн арга, загварчлал, ур чадвар, технологийг хослуулан ажиллаж байна. Дээрх чиглэлийн 20+ төслийг амжилттай хэрэгжүүлээд байна.



БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Бид албан ёсны эх сурвалж бүхий нээлттэй мэдээллийн санд тулгуурлан салбар болон зах зээлийн судалгааг өөрсдийн санаачилгаар жил бүр тодорхой сэдвийн хүрээнд хийж, олон нийтэд үнэгүй хүргэж байна. Энэ судалгааны хүрээнд нийтдээ 15 төслийг амжилттай хэрэгжүүлэв. Энэхүү төслийн хүрээнд цаашид нийгэмд хэрэгтэй, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжсэн төслүүдийг хамтран хэрэгжүүлэх үүд хаалга нээлттэй байгааг хэлэхэд таатай байна.

БАЙГУУЛЛАГЫН ТЕХНИКИЙН ЧАДАВХИ

"Манай байгууллага өөрийн эзэмшлийн оффис, жижиг, том хурлын өрөөтэй. Мөн мэргэжлийн компьютер, чихэвч зэрэг тоног төхөөрөмжөөр тоноглогдсон утсаар судалгаа авах өрөө, фокус бүлгийн ярилцлага хийх тусгайлан зассан өрөөтэй"



МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА

Мэдээлэл цуглуулахад ашигладаг арга:

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа CSPro, Google Forms, Kobo toolbox, Survey Monkey зэрэг программыг ашигладаг. Мөн үүрэн холбооны операторууд болон утсаар судалгааны мэдээлэл цуглуулах үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтран ажилладаг.

CATI

Утсаар судалгаа авах арга



ДАВУУ ТАЛУУД:

- Судалгааг бага зардлаар, богино хугацаанд хийх;
- Монголын хаанаас ч мэдээлэл цуглуулах боломжтой;
- Судалгааны мэдээлэл цуглуулалтын бүх үе шатыг программчилсан тул алдаа гарахгүй;
- Ярилцлага тус бүрийн аудио бичлэгийг хийж шалгах;
- Судалгааны түүвэр болон квотыг хянах;
- Судалгааны мэдээлэл автоматаар серверт хадгалагддаг.

ДАВУУ ТАЛУУД:

- Судалгааг бага зардлаар, богино хугацаанд хийх;
- Судалгааны мэдээлэл цуглуулалтын бүх үе шатыг программчилсан тул алдаа гарахгүй;
- Аль цэгээс судалгаа авсныг GPS-ээр тодорхойлох, хянах, удирдах;
- Онлайн болон оффлайн ямар ч тохиолдолд ашиглах боломжтой;
- Ярилцлагын аудио бичлэг хийх, зураг авч баримтжуулах;
- Мэдээлэл цуглуулах, оруулах, хянах үйлдлийг нэг дор хийж, өгөгдлийг шууд дамжуулах;



CAPI

Таблетаар мэдээлэл
цуглуулах арга

CAWI

Интернэтээр мэдээлэл
цуглуулах арга



ДАВУУ ТАЛУУД:

- Зардал бага
- Хүн, хүч бага шаардана
- Зорилтот хэрэглэгчдийг судалгаанд хамруулах боломжтой
- Интернэттэй бүх газраас судалгаанд оролцох боломжтой
- Мэдээллийн санг тухай бүрд нь хянах, шалгах боломжтой
- Дүрс, дуу, бичлэг үзүүлэх байдлаар судалгааг явуулах боломжтой.

ПРОГРАММ ХАНГАМЖ

Мэдээлэл боловсруулахад ашигладаг программ:

Судалгааны тоон ба чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ SPSS, STATA, EViews, R, QDA miner зэрэг программ ашигладаг. Мөн байгууллагын хэмжээнд Office 365 программыг ашиглаж байна.




ПРОГРАММ ХАНГАМЖ

GPS-ИЙН ХЯНАЛТ

Түүнчлэн судалгааны байршлаа олох болон тухайн зорилтот байрлал, судалгаанд оролцогч (респондент)-оос судалгааг авч байгаа эсэхийг төв оффисоос GPS-ийн (www.gps.clix.mn) системийг ашиглан зааварчилгаа өгч, байнгын хяналт хийн ажилладаг. Тус программыг судлаачийн гар утсанд суулгаж өгснөөр уг хяналтыг хийх ба дараах тайланг гаргах боломжтой.

1. Утасны GPS салсан цагийн бүртгэл
2. Туулсан замын тайлан
3. Очсон цэгүүдийн дараалал
4. Зочлолтын тайлан



ТҮҮХЭН ЗАМНАЛ

2008

Бидний эхлэл
Үйл ажиллагаа
явуулж эхлэв

2013

Шинээр байгуулагдав
МИРИМ Консалтант ХХК
шинээр байгуулагдаж
МТҮП-ийн Инкубатор
хөтөлбөрт хамрагдав.

2014

Бизнесийн өргөжилт
ЕСБХБ-ны бизнесийн
зөвлөх үйлчилгээний
гишүүн байгууллага
болов.

2016

Брэндбүүкээ
шинэчлэв
Байгууллагын
брэндбүүкээ шинэчилж,
сайжруулав.

2018

Брэнд судалгаа
МИРИМ Консалтант компани
өөрийн нэрийн брэнд
судалгааг хөгжүүлж, анхны
бүтээгдэхүүнийг гаргав.

2015

Шинэ оффистой болов
МИРИМ Консалтант компани нь
өргөжин тэлж өөрийн эзэмшлийн
оффистой болов.

2017

Стратегия тодорхойлов
Байгууллагынхаа дунд хугацааны
стратегийг баталж, стратегийн
чиглэлүүдээ тодорхойлов.

2019

Үндэсний хэмжээний
хурлыг зохион байгуулав
“Монгол улсын жижиг, дунд
бизнесийн хөгжлийн өнгөрсөн,
одоо, ирээдүй: Зөвлөх
үйлчилгээний үнэ цэн” хурлыг
амжилттай зохион байгуулав.

2021

ISO 9001:2015 нэвтрүүлээ
Олон улсын
баталгаажуулалтын
байгууллагаар баталгаажсан
ЧМТ-ны ISO 9001:2015 албан
ёсны гэрчилгээг хүлээн авсан.

2020

ISO 9001:2015 нэвтрүүлэв
Чанарын менежментийн
тогтолцооны ISO9001:2015 олон
улсын стандартын сургалтыг
авч, гэрчилгээ авахад бэлэн
болов.





□ **Холч Голч Бүтээлч...**



(976)-70137012



contact@mirim.mn



Монгол улс, Улаанбаатар 14181,
Сүхбаатар дүүрэг, 11-р хороо,
ПроВан барилга, 15 давхар,
1502 тоот



www.mirim.mn